

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025.12.25

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Хэрэгжилт	Хувь/үзүүлэлт
Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг төлөвшүүлэх			
1.1	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн даган мөрдөх журмыг А/456, ЭХЭМҮТ-ийн 523 тоот тушаалыг таниулан сурталчлах, мөрдлөг болгон хэвшүүлэх	➤ Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн даган мөрдөх журмыг А/406, ЭХЭМҮТ-ийн 523 тоот тушаалыг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг эрх зүйн баримтуудыг тасгийн бүх ажилчдад тарааж уншуулж судлуулах зөвлөмж өгч ажиллав. ➤ Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль болон MNS 7014:2023 стандартыг тасаг нэгж бүрт таниулан сурталчилж, мэдээллэлийн самбарт байршуулан, мөрдлөг болгон хэрэгжүүлж байна. ➤ <i>Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль</i>” сэдэвт сургалт авах албан бичгийг төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. 2025 оны III- улиралд багтаан сургалт явуулахаар захиалга өгсөн.	100%
1.2	Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль болон MNS 7014:2023 стандартыг таниулан сурталчилж мөрдлөг болгон хэрэгжүүлэх		
1.3	Шинээр ажилд орж байгаа эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүйн мэдлэгт үнэлгээ хийх, сувилахуйн тестыг боловсруулах	2025 оны 1-р сарын 25-наас хойш ЭХЭМҮТ-д шинээр ажилд орсон нийт эмч, сувилагч болон бусад ажилтнууд хамрагдсан бөгөөд тэдний ёс зүйн мэдлэгийн тестийг боловсруулан сорил авч үнэлсэн. Тестийн дүнгийн үр дүнг доорх байдлаар дүгнэв: • 70% нь 80%-иас дээш амжилт үзүүлсэн • 30% нь 70%-ийн түвшинд Үр дүнд тулгуурлан мэргэжлийн бүлгүүдээр ангилан сургалт зохион байгуулж, мэдлэгийн түвшинг ахиулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. • Дэмжих үйлчилгээний албанд шинээр ажилд орсон ажилтнуудад “Эмнэлгийн ёс, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулсны дараа тестийн шалгалт авах • Эмч, сувилагч нараас эхэлж ёс зүйн мэдлэгийн тестийн үнэлгээг урьдчилан авсны үндсэн дээр сургалтыг зорилтот байдлаар зохион байгуулах • Сургалтын чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр салбар бүрт чиглэсэн арга зүйг боловсруулан хэрэгжүүлж байна.	100%

1.4	Эмнэлгийн мэргэжилтний Ёсзүйн дүрмийг Хэн сайн мэдэх вэ? Хөгжөөнт АХА тэмцээн зохион байгуулах	Нийт тасаг нэгжийн дунд "АХА" тэмцээнийг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр амжилттай зохион байгууллаа. ТЭРГҮҮН байранд Үргүйдэл, нөхөн үржихүйн төвийн үр хөврөл судлаач Б.Ганбаяр (Өргөмжлөл, 250.000 төгрөг) ДЭД байранд Радиологийн тасгийн дүрс оношилгооны техникч Э.Нямжаргал (Өргөмжлөл, 150.000 төгрөг) ГУТГААР байранд Нийгмийн эрүүл мэнд, сургалт, маркетингийн албаны мэргэжилтэн Д.Пүрэвдаваа (Өргөмжлөл, 100.000 төгрөг) нар шалгарсан.	100%
1. Эмнэлэгийн мэргэжилтний Эрхзүйн мэдлэг болон Ёсзүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалт			
2.1	Эмч, эмнэлэгийн мэргэжилтэн нарт Ёс зүйн мэдлэгийг үнэлэх, сургалт явуулдаг төрийн ба ТББ-тай хамтран ажиллах, кредиттэй сургалтыг зохион байгуулах	- Нарны шаргал туяа ТББ-тай хамтран “Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн шинэ ойлголт” сэдвээр 1.5 багц цагийн сургалт зохион байгуулж, нийт 170 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан” - ЭМЯ-ны ЁЗХХ-той хамтран ЁЗХХ-ны дарга АУ-ны доктор дэд проф. Д.Оюунбилэг, Иргэдийн өргөдөл гомдол хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн дарга Ш.Оюунчимэг, ЁЗХХ-ны гишүүн АШУ-ны доктор проф. Б.Саранцэцэг багш нар ёс зүйн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд ЭХЭМҮТ-ийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нарын 110 ажилтан хамрагдсан. - Хуульч, өмгөөлөгч Э.Ганбат багш “Эмнэлэгийн эрх зүй” сэдэвт сургалт 4 цагийн лекцыг зохион байгуулж ЭХЭМҮТ-ийн 160 эмч, сувилагчийг хамруулсан. “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” аяныг зохион байгуулж ЭХЭМҮТ-ийн нийт ажилчдыг хамруулсан. /тайланг хүргүүлэв/	100%
2.2	Сувилагч, эх баригч нарт “Ажлын байрны стрессийг тайлах, Инээмсэглэл-2025” сургалтын төлөвлөгөө боловсруулж зохион байгуулах	1) “Ажлын байрны стрессийг тайлах, Инээмсэглэл-2025” Сэтгэл зүйн сургалт – Эмзүйчдэд: 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 09:00–10:15 цагийн хооронд “Стресс менежмент” сэдэвт сургалтыг Эмзүйн тасгийн 18 эмзүйчид зориулан зохион байгууллаа. 2) Сувилагч, Эх баригч нарт: 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр 09:00–10:15 цагийн хооронд “Стресс менежмент” сэдэвт сургалтыг Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн Мэдээгүйжүүлэх, хагалгааны	100%

		нэгдсэн тасгийн 20 эх баригч, сувилагч, үйлчлэгч нарт зохион байгуулсан бөгөөд сургалтад Зөвлөгөө, мэдээллийн ажилтан Б.Отгонханд “Хүндлэх ёс” сэдвээр хамтран оролцож, мэдээлэл өгсөн. 3) Ганцаарчилсан зөвлөгөө: 2025 оны эхний хагас жилийн хугацаанд ЭХЭМҮТ-ийн нийт 7 ажилтан сэтгэл зүйчээс ганцаарчилсан зөвлөгөөнд нийт 15 удаа хамрагдсан байна.	
2.3	Шинээр ажилд орж буй ажилчдад, резидент эмч нарт ёс зүй, харьцаа хандлагын сургалт явуулах, ёс зүйн тангараг өргүүлэх	- Шинээр ажилд орж буй эмч, резидент эмч нараас бүрдсэн нийт 120 хүнд зориулан ёс зүй, харьцаа хандлагын сургалт зохион байгуулж, ёсзүйн мэдлэгт үнэлгээ хийх, ёсзүйн тангараг өргүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 2025 оны 1-р сарын 25-наас хойш шинээр ажилд орсон нийт 110 ажилтанд нийт эмнэлгийн ёс зүйн 4 удаагийн сургалт зохион байгуулсан.	100%
2. Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах			
3.1	ЁЗСХ-ны ажлын төлөвлөгөөг тогтмол хэлэлцэн баталж хэвших, үйл ажиллагааг тогтмолжуулах	2025 оны 02-р сарын 21-нд ЭХЭМҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг Ерөнхий захирлын тушаалаар батлуулсан. Ёсзүйн салбар хороо нь 2025 онд нийт удаа хуралдаж ажилласан.	100%
3.2	ЁЗСХ-ны мэдээлэлийн сан байгуулах вэб хуудсанд мэдээлэл байрлуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	A/406, ЭХЭМҮТ-ийн 523 тоот тушаалыг, хурлаас гарсан зөвлөмж, ёсзүйн хэм хэмжээтэй холбоотой мэдээ мэдээллийг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарт танилцуулах ажлыг зохион байгуулан эмч, сувилагч нарын яриа, төвийн дотоод, гадаад цахим хуудас болон “Ёсзүйн самбар”-т байршуулж тогтмол мэдээлж байна. Мөн Ёс Зүйн Үндэс Мод загварыг санаачлан, QR-кодыг уншуулан тушаал, зөвлөмж, мэдээлэлийг иргэн бүрт хүртээмжтэй хүргэхээр тасаг, нэгжийн өрөөний хаалга бүрт байршуулсан.	100%
3.3	Ёс зүйн салбар хорооны хурлыг сар бүрийн сүүлийн долоо хоногт болон шаардлагатай тохиолдолд товлон харгалзахгүй хийж асуудлыг тухай бүр шийдвэрлэх	2025 онд ЁЗСХ- нь нийт 12 удаа хуралдсан. А. 2025 оны 01 сарын 24 өдөр 1. Хэлэлцэх асуудал: - Ёс зүйн салбар хорооны гишүүдийг сонгон шалгаруулсан тухай танилцуулах - Ёс зүйн салбар хорооны гишүүд хоорондоо танилцах - Ёс зүйн салбар хорооны дарга, орлогч даргыг гишүүдийн санал хураалтаар сонгох	100%

		4. Ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, цаашид хэрхэн ажиллах талаар санал авах тухай 5. Г.Оюундарь эмчид холбогдох өргөдлийг танилцуулах Хурлын шийдвэр: 6. Гишүүдийн санал хураалтаар ЁЗСХ-ны даргаар Э.Энхнаран, орлогч даргаар Г.Сансар нар ажиллахаар сонгогдов. 7. Бүх гишүүдийг ёс зүйн холбогдох журам тушаалтай танилцахыг үүрэг болгов. 8. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд гишүүдээс нээлттэй санал авахаар шийдвэрлэв. 9. Г.Оюундарь эмчтэй холбоотой асуудлаар тайлбар авч судлах ажлыг Э.Энхнаран, Р.Оргилмаа нарт үүрэг болгов. 10. Эмч нарын сургалтын материалыг ажилласан жилээс нь хамааран өөр өөр агуулгатай бэлдэхийг Н.Алгирмаа, Г.Сансар нарт үүрэг болгов 11. Эмнэлгийн тусгай мэргэжилтэн, сувилагч нарт зориулсан сургалтын материал бэлтгэхийг Р.Оргилмаа, Д.Батбаяр нарт үүрэг болгов. 12. Дэмжих үйлчилгээний албан хаагчдад зориулсан сургалтын материал бэлдэхийг Б.Дэлгэрмаа, Б.Мөнхшүр нарт үүрэг болгов. 13. Зөвлөх эмч, удирдах ажилтнуудад зориулсан сургалтын дата судлах ажлыг Ч.Болдбаатар, Б.Мөнхшүр, Б.Дэлгэрмаа нарт даалгав. Б. 2025 оны 02 сарын 18 өдөр 14. Ёс зүйн салбар хороо байгуулсан тухай Төвийн Ерөнхий захирлын тушаал, ЭМС-ын 2017 оны А/256 тоот тушаал болон шинэчлэн байгуулагдсан салбар хорооны гишүүдийн ажиллах чиг үүргийг танилцуулах 15. ЁЗСХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх 16. Өсвөр үеийн клиникийн их эмч Г.Оюундарьтай холбогдох асуудал 17. Төрсний дараах тасгийн эрхлэгч Ж.Энхтуяатай холбогдох өргөдлийг танилцуулах 18. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн урамшуулал олгох тухай Хурлын шийдвэр:	
--	--	---	--

		19. Ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусган батлуулахыг ЁЗСХ-ны дарга Э.Энхнаранд даалгав. 20. Г.Оюундарь, Ж.Энхтуяа эмч нартай холбогдох асуудлаар тодруулах зүйлсийг судлаж нягтлахыг ЁЗСХ-ны гишүүдэд үүрэг болгов. 21. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг олгуулахаар шийдвэрлэв. В. 2025 оны 03 сарын 12 өдөр Хэлэлцэх асуудал: 22. Төрсний дараах тасгийн эрхлэгч Ж.Энхтуяатай холбогдох асуудал 23. Өсвөр үеийн клиникийн их эмч Г.Оюундарьтай холбогдох асуудал 24. Ёс зүйн салбар хороонд үйлчлүүлэгчийн төлөөлөл, гишүүн сонгон шалгаруулж авах тухай 25. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн урамшуулал олгох тухай Хурлын шийдвэр: 26. Төрсний дараах тасгийн эрхлэгч Ж.Энхтуяаг ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд, Төвийн захиргаанд хаалттай сануулах сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв. 27. Өсвөр үеийн клиникийн их эмч Г.Оюундарийг ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд, Төвийн захиргаанд хаалттай сануулах сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв. 28. Үйлчлүүлэгчийн төлөөлөл гишүүн сонгон шалгаруулж авах тухай зарыг Төвийн гадаад хуудсанд нээлттэй байршуулахаар шийдвэрлэв. 29. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв. Г. 2025 оны 04 сарын 25 өдөр Хэлэлцэх асуудал: 30. Ёс зүйн салбар хороонд үйлчлүүлэгчийн төлөөлөгч гишүүн авах асуудлын тухай 31. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн 2025 оны 04 дүгээр сарын урамшуулалт цалинг олгох тухай	
--	--	--	--

ХУРЛЫН ШИЙДВЭР:

32. Үйлчлүүлэгчийн төлөөлөгч гишүүнээр ажиллах хүсэлтэй иргэний хүсэлтийг авч танилцуулахыг ЁЗСХ-ны нарийн бичгийн дарга Б.Мөнхшүрд үүрэг болгов.

33. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв.

Д. 2025 оны 05 сарын 29 өдөр**Хэлэлцэх асуудал:**

34. ЭМЯ-ныдэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 25/08 дугаар тогтоол танилцуулах

35. ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны үйлчлүүлэгчийн төлөөлөгч гишүүн Б.Бүрэнжаргалыг танилцуулах

36. Б.Болорхорлоогоос ирүүлсэн гомдлыг хэлэлцэх

37. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн 2025 оны 05 дугаар сарын урамшуулалт цалинг олгох тухай

ХУРЛЫН ШИЙДВЭР:

38. Үйлчлүүлэгчийн төлөөлөгч гишүүнээр ажиллах хүсэлтэй иргэний хүсэлтийг авч танилцуулахыг ЁЗСХ-ны нарийн бичгийн дарга Б.Мөнхшүрд үүрэг болгов.

39. Б.Болорхорлоогоос ирүүлсэн гомдлыг хэлэлцэн эвлэрүүлэн зуучлав, тасагт нь сэтгэлзүйн зөвөлгөө өгөхийг Б.Дэлгэрмаад үүрэг болгов.

40. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв.

Е. 2025 оны 06 сарын 18**Хэлэлцэх асуудал:**

41. ЭМЗТ-ийн эмч Л.Батзулын ирүүлсэн НҮЗП-ийн эмч Ц.Болормаатай холбогдох гомдлыг танилцуулах

42. Хагас жилийн тайланг хэлэлцэх

ХУРЛЫН ШИЙДВЭР:

43. ЭМЗТ-ийн эмч Л.Батзулын ирүүлсэн НҮЗП-ийн эмч Ц.Болормаатай холбогдох мэдээлэлийг цуглуулах ажлыг Б.Дэлгэрмаа, Б.Мөнхшүр нарт даалгав.

44. Хагас жилийн тайланг дүгнэж бичихийг Э.Энхнаранд даалгав.

Ё. 2025 оны 06 сарын 20 өдөр

45. ЭМЗТ-ийн эмч Л.Батзулын ирүүлсэн НҮЗП-ийн эмч Ц.Болормаатай холбогдох гомдлыг хэлэлцэх

46. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн 2025 оны 06 дугаар сарын урамшуулалт цалинг олгох тухай

ХУРЛЫН ШИЙДВЭР:

47. Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн эмч Ц.Болормаа ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд, Төвийн захиргаанд хаалттай сануулах сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

48. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв.

Ж. 2025 оны 08 сарын 29 өдөр

49. ЭМЗТ-ийн тасгийн эрхлэгч Л.Батзулын гаргасан өргөдөлийн дагуу НҮЗП-ийн их эмч Ц.Болормаатай гаргасан ёс зүйн зөрчилийг шийдсэн хэмээн ЭМЯ-ны дэргэдэх ёс зүйн хороонд албан бичиг явуулах тухай

50. Ёс зүйн салбар хороонд гишүүн сонгон шалгаруулж авах тухай

51. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн урамшуулал олгох тухай

ХУРЛЫН ШИЙДВЭР:

52. ЁЗСХорооны гишүүд ЭМЗТ-ийн эрхлэгч Батзул болон НҮЗП-ийн их эмч Ц.Болормаатай холбоотой асуудлын бичиг баримтыг хянан шалгаж, гаргасан ёс зүйн зөрчлийг өргөдөлүүдийн дагуу шийдсэн хэмээн ЭМЯ-ны дэргэдэх ёс зүйн хороонд албан бичгийн хариуг явуулахаар шийдэв.

53. Шинэ гишүүнээр Б.Бүрэнжаргалыг сонгон шалгаруулж авлаа.

54. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв.

З. 2025 оны 09 сарын 11 өдөр

55. Хүүхдийн эмнэлгийн Хүүхдийн эмнэлгийн мэдээгүйжүүлэх хагалгааны тасгын сувилагч С.Батсайхан холбогдох асуудал

56. Ёс зүйн салбар хороонд үйлчлүүлэгчийн төлөөлөл, гишүүн сонгон шалгаруулж авах тухай

		57. Ёс зүйн салбар хорооноос өргөдөл, гомдолд гаргасан шийдвэрийг дараагийн шатанд хэрэгжиж байгаа эсэхэд хяналт хийх тухай 58. ГНДНЭЭТ-ийн Б.Өлзийхишигийн гаргасан өргөдөл, гомдлыг хэлэлцэх. ХУРЛЫН ШИЙДВЭР: 59. Хүүхдийн эмнэлгийн мэдээгүйжүүлэх хагалгааны тасагын сувилагч С.Батсайханыг ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд, Төвийн захиргаанд хаалттай сануулах сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв. 60. Үйлчлүүлэгчийн төлөөлөл гишүүн сонгон шалгаруулж авах тухай зарыг Төвийн гадаад хуудсанд нээлттэй байршуулахаар шийдвэрлэв. 61. Ёс зүйн салбар хорооноос өргөдөл, гомдолд гаргасан шийдвэрийг дараагийн шатанд хэрэгжиж байгаа эсэхэд хяналт хийхийг ЁЗСХ-ны нарийн бичгийн дарга Б.Мөнхшүрд үүрэг болгов. 62. ГНДНЭЭТ-т ирсэн Б.Өлзийхишигийн асуудлыг дараагийн хурлаар шийдвэрлэхээр болж холбогдох нэмэлт тодруулгыг ЭБЭЭ-ийн баг хариуцаж авахаар болов. И. 2025 оны 09сарын 20 өдөр 63. Зэргийн шалгалттай холбоотой Ёс зүйн дүгнэлтийг танилцуулах 64. Үргүйдэлийн нөхөн үржихүйн төвийн техникч З.Энхбаяртай холбоотой асуудлыг хэлэлцэх 65. НСТ-ийн их эмч Д.Азжаргалтай холбоотой асуудлыг хэлэлцэх 66. Ёс зүйн салбар хорооны гишүүдийн урамшуулал олгох тухай ХУРЛЫН ШИЙДВЭР: 67. Нярай судлалын тасгийн эмч Н.Азжаргал нь удаа дараа ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд, Төвийн захиргаанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв. Н.Азжаргал нь 2024 онд мөн ёс зүйн хурлаар орсон ба жилийн дараа ахин Ёс зүйн хурлаар орж байгаа тул тухайн тасагт ёс зүйн сургалт хийж тайланг тасгийн эрхлэгч Ёс зүйн хороонд бичгээр өгөхөөр шийдвэрлэв.	
--	--	--	--

		68. ҮНҮТ-ийн техникч З.Энхбаяр зөрчил гаргасан байна гэж дүгнээд хаалттай сануулах арга хэмжээг авах, мөн холбогдох тасгийн эрхлэгчид хурлын шийдвэрийг хүргүүлэхээр шийдвэрлэв. 69. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв. Й. 2025 оны 10 сарын 28 өдөр 70. 2025 оны төлөвлөгөөтэй холбоотой биелэлтийн хяналт 71. Үйлчлүүлэгч төлөөлсөн гишүүн томилох 72. Нярай судлалын тасгийн эмч Д.Азжаргалд холбогдох өргөдөл, Хүүхдийн зөвлөх поликлиникийн эмч М.Оюун-Эрдэнэд холбогдох 1111 төвийн өргөдлийг хэлэлцүүлэх 73. Сар бүрийн хурал, протоколын хяналт 74. Ёс зүйн салбар хорооны мэдээллийн самбар 75. Маргаан эвлэрүүлэн зуучлах тайлан 76. Ёс зүйн зөрчилд судалгаа хийх 77. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа 78. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийн мэдээлэл ХУРЛЫН ШИЙДВЭР: 79. 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг баталж, сар бүр хяналт тавина. 80. Үйлчлүүлэгч төлөөлсөн гишүүнийг ХНАлба он гарахаас өмнө олж томилуулах. 81. Ирсэн хоёр өргөдлийг 11-р сарын 20-ноос өмнө шийдвэрлэх. 82. “Ёс зүйн зөрчлийг үл тэвчий” аяныг баталсан хугацаанд хэрэгжүүлэх. 83. АХА тэмцээнийг 11-р сарын дунд зохион байгуулах. 84. Б.Бүрэнжаргал, Б.Мөнхшүр, Д.Дэлгэрмаа, Сансар нар хариуцах чиг үүргийг баталгаажуулсан. 85. Гомдол, өргөдлийн бүх баримтыг бүрдүүлж, протоколжуулж архивлана. 86. Жилийн эцсийн тайланг 12-р сарын эхний долоо хоногт авч нэгтгэнэ.	
--	--	---	--

		К. 2025 оны 11 сарын 3 өдөр 87. 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг батлах 88. “Ёс зүйн зөрчлийг үл тэвчий” аяныг баталсан хугацаанд хэрэгжүүлтийг хянах 89. ЁЗСХ-ны дэд даргад түр тамга шилжүүлэх, ажил үүргийн хуваарилалтыг хэлэлцэх 90. ЁЗСХ-ны урамшуулалт цалинг олгох тухай ХУРЛЫН ШИЙДВЭР: 91. 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг батлав. 92. “Ёс зүйн зөрчлийг үл тэвчий” аяныг баталсан хугацаанд хэрэгжүүлтийг хянах үүргийг ЁЗСХ-ны нарийн бичгийн дарга Б.Мөнхшүрт хариуцуулав. 93. ЁЗСХ-ны даргийн түр орлох ажлыг дэд дарга Г.Сансарт хариуцуулан тамгыг гардуулан өгөв. 94. Ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үндсэн цалингийн 20%, гишүүдэд үндсэн цалингийн 10%-ийн цалинг бүтэн олгуулахаар шийдвэрлэв.	
3.4	Албан хаагч, үйлчлүүлэгч хоорондын ёс зүйн маргааны үед хүсэлтийн дагуу эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлэх	2025 оны 03 сарын 12 өдөр 1. Өсвөр үеийн клиникийн их эмч Г.Оюундарь болон үйлчлүүлэгчтэй холбогдох асуудалыг хэлэлцэж, хуулийн дагуу шийдвэрлэсэн. 2. - Үйлчлүүлэгчдээс ирсэн 6 санал гомдлын дагуу хуулийн хугацаанд эвлэрүүлэн зуучлан, хуулийн дагуу шийдвэрлэсэн 3. НЭСТ-ийн ёс зүйн маргааныг эвлэрүүлэн зуучилсан 4. ХЗП-ийн хөтөч болон үйлчлүүлэгийн хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлав. 5. Нярай судлалын тасгийн эмч Н.Азжаргал болон Л.Ролзодмаа эмч нарын маргааныг эвлэрүүлэн зуучлав.	95%
3.5	Ёс зүйн алдаанд судалгаа хийж, зөвлөмж боловсруулан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг мэдээллээр хангах, санал хүргэх	Ёсзүйн алдаатай холбогдох судалгааны үнэлэлтийн үр дүнд үндэслэн мэргэжлийн бүлгээр ангилан сургалт зохион байгуулж, тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
3.6	Үйлчлүүлэгчийн эрх үүргийг сурталчлан цахим орчинд байршуулах		100%

3.7	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг бар кодоор авах, ил тод байршуулалтыг хэрэгжүүлэх	• Үйлчлүүлэгчдээс ирүүлсэн талархал, санал, хүсэлтийг долоо хоног бүрийн мягмар гаригт зохион байгуулагддаг эмч нарын хурал дээр танилцуулж байна. • Үйлчлүүлэгчийн эрх, үүргийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан цахим орчин дбайршуулсан. • Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг QR кодоор авах нөхцөлийг бүрдүүлж, үнэлгээний ил тод байдал, оролцоог хангах үүднээс тасаг, нэгж бүрт болон амбулатори, ЯТТ-ийн үзлэгийн өрөөнд байршуулалт хийж, зөвлөмж боловсруулан гаргасан.	100%
3.8	Мэргэжлийн зэрэг горилогчийн Ёсзүйн дүгнэлт гаргах	Дээрхи хугацаанд мэргэжлийн зэрэг горилогчийн 52 Ёсзүйн дүгнэлтийг багаар хянан хэлэлцэж гаргасан.	100%
3. Үйлчлүүлэгчдийн эмнэлгийн байгууллагад хандах хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа			
4.1	Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ баримтлах эрх үүргийг сурталчилах, Зөрчлийн хуулийг сурталчилан таниулах 5.2 заалт хавсаргах	• Зөрчлийн тухай хуулийн 15.6 дугаар зүйлийн холбогдох заалтыг тасаг, нэгж, амбулатори болон ЯТТ-ийн үзлэгийн өрөөнд сурталчилан байршуулсан.	95%
4.2	Үйлчлүүлэгчийн санал гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, судалгаа дүгнэлт гаргах	• Үйлчлүүлэгчдээс ирсэн 6 санал гомдлын дагуу хуулийн хугацаанд эвлэрүүлэн зуучлан, хуулийн дагуу шийдвэрлэсэн.	100%
4.3	Үйлчлүүлэгчийг Мэндэлж угтаж-Инээмсэглэн үдэх стандартыг хэрэгжүүлэх,/хувцаслалт/MNS 7014:2023 стандартыг таниулан сурталчилж мөрдөх	• Дэмжих үйлчилгээний 19 ажилтанд зориулан “Мэндэлж угтаж-Инээмсэглэн үдэх, ажлын байрны хувцаслалтын стандарт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.	100%

Тайлан гаргасан: Ёсзүйн салбар хорооны дарга

Э.ЭНХНАРАН